

*Улаанбаатар хот*  
Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Зарлах огноо: 2020-03-16

“ДЦС-3” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Гүүрэн крануудад иж бүрэн оношлогоо, техникийн иж бүрэн магадлал хийлгэх ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах” тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Үнийн саналыг **2020 оны 03-р сарын 23-ний өдрийн 10.00 цагаас** өмнө Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр илгээнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 03-р сарын 23-ний өдрийн 10:05-д** цахим системээр нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: тооцохгүй  
Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо,  
“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, 2 давхар  
Хангамжийн хэлтэс: Утас: 70111304, Факс: 344111.  
Веб хуудас: [www.tes3.energy.mn](http://www.tes3.energy.mn)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]   |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>30</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.  |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 1 жил (2019 он)-ийн жилийн санхүүгийн тайлан ирүүлэх. (Аудитаар баталгаажуулсан байх)</li> <li>2. Сүүлийн 2 жил(2018,2019 он)-ийн туршлагын мэдээлэл (гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар хуулбар)</li> <li>3. Компанийн болон НӨАТ-н гэрчилгээний хуулбар</li> <li>4. Компанийн товч танилцуулга</li> <li>5. Ажлыг хийж гүйцэтгэх багаж, техник хэрэгслэл, ажиллах хүчний мэдээлэл тус хавсаргана.</li> <li>6. Татварын албаны цахим тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй Тендер нээсэн өдөр системээс татаж харна. (Өргүй байх)</li> <li>7. Харьяалагдах нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт. ( Өргүй байх)</li> <li>8. Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь, төсөв</li> </ol> <p><b>Дараахь тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай</b>            Барилга хот байгуулалтын яамны доорхи зөвшөөрлүүд:            -4.2 Өргөх байгууламж            -MNS ISO17020 итгэмжилэл</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:            Төрийн худалдан авах ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>            Огноо:2020 оны 03-р сарын 23-ний өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендер нээлт хийх газар хугацаа нь:            Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, 2 давхар 215 тоот</p> <p>Огноо:2020 оны 03-р сарын 23-ний өдөр            Цаг: 10 цаг 05 минут</p>
ТӨӨЗ 5.1	Техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар ирүүлэх
ТӨӨЗ 7.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй

## **Дөрөв:ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

“Гүүрэн крануудад иж бүрэн оношлогоо, техникийн иж бүрэн магадлал хийлгэх ажлын” ажил гүйцэтгэхдээ тендерийн материалын 5-р бүлэгт заагдсан ажлын эзэлхүүнд тусгагдсан бүх ажлыг узель зангилаа бүрд бүрэн хэмжээгээр чанартай гүйцэтгэнэ. Ажлын явцад ажлын эзэлхүүнээс нэмэгдэх хасагдах зүйл гарч болно. Гарсан нэмэгдэл ажлыг магадлашгүй ажлын зардлаар хийнэ. Магадлашгүй ажлын зардал болон НӨАТ - г гүйцэтгэгч төсөвтөө тусгаж өгнө. Захиалагч нэмэлт ажлын төсөв зардал гэж тусдаа гаргахгүй .

Засварын ажлыг гүйцэтгэхдээ засварын технологиудыг чанд баримталж ажиллах, шаардлагатай үед МЕХАНИК ЦЕХИЙН өргөх зөөх механизмыг хариуцсан ИТА, мэргэжилтэнүүдтэй зөвлөлдөж тусгай технологи гаргаж түүний дагуу засварын ажил гүйцэтгэх ёстой. Дур мэдэн ямар нэг өөрчлөлт, технологи хэрэглэхгүй байх.

Захиалагч засварын технологийн мөрдөлт, засварын чанар, материал сэлбэг зарцуулалт, ажлын гүйцэтгэлд төслийн менежер болон захилагчийн мэргэжлийн инженер, мастерууд хяналт тавьж ажиллана.

## **ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ТЕНДЕРИЙН ШААРДЛАГА, ТЕНДЕРИЙН НӨХЦЛҮҮД**

### **1.ТЕНДЕРИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

1. Энэхүү засварын сэлбэг, материалыг нийлүүлэх болон засварын ажлыг 45 хоногт буюу 3,4-р сард бүрэн хэмжээгээр хийсэн байна.
2. Засварын ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах авто машин кран, хийц, эд ангиуд, тэдгээрийг үйлдвэрлэх, нийлүүлэх, техникийн зураг, техникийн детальчилсан зураг гаргах, зорлого хийх, матах, өрөмдөх, хуйлах ажлын хөлс, турших тохируулахад гарах зардал болон бусад зардлыг гүйцэтгэгч бүрэн хариуцах бөгөөд зардлуудыг сонгон шалгаруулалтын материалд тусгасан байвал зохино.
3. Тендерийн заавал биелүүлэх нөхцөл, тендерийн шаардлага, ХАБЭА-н шаардлагуудад шаардагдах хөрөнгийг гүйцэтгэгч хариуцахаар тусгах шаардлагатай.
4. Гүйцэтгэгч компани хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн байцаагч инженер томилон ажиллуулна. Засварын ажлын явцад ХАБЭА-н зөрчил доголдолгүй ажиллуулах ажил зохион байгуулах үүргийг гүйцэтгэгч байгууллагын удирдлага, ажлын нарыдаар үүрэг хүлээгчид шууд хариуцна.

### **2. ЗАСВАР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРУУЛ АХУЙН ШААРДЛАГА**

1. Засварт оролцох гүйцэтгэгч байгууллагын ( туслан гүйцэтгэгч мөн хамаарна ) ажиллагсад нь Эрчим хүчний үйлдвэрт мөрдөгдөж байгаа ТАД, ААД, ГАУСД, ХАБЭА хуулийн зохих мэдлэгтэй, ээлжит шалгалт өгсөн мэргэжлийн үнэмлэхтэй, оосорлогч дохиочноор ажиллах хүмүүс мэргэжлийн үнэмлэхтэй байна.

2. Тухайн ажлын байранд ажиллах хүмүүс шаардлагатай хамгаалах хэрэгсэл, ХАБЭА-н хувцасаар бүрэн хангагдсан, эрүүл мэндийн үзлэгт орсон, энэ ажилд эрүүл мэндээр тэнцэх хүмүүс байна.
3. Ажлын байрыг байнга эмх цэгцтэй, хог хаягдлыг тухай бүр нь зайлуулж, шат тавцангууд болон эд ангиудыг шуурхай ажиллагаанд /ашиглалтын ажилд/ саад болохооргүй чөлөөтэй байлгах үүрэг хүлээнэ.
4. Засварт оролцох гадны байгууллагын ажиллагсад нь “ДЦС-3” ТӨХК-ийн дотоод дүрэм журам, ХАБЭА-н талаар мөрдөгдөж байгаа дүрэм, журам эдгээрийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, торгууль, шийтгэлийг мөн адил мөрдөж ажиллах үүрэгтэй.
5. Ажлын онцлогоос хамааруулж зарим нэг тоноглол, үзельд засвар хийхдээ тусгай шат тавцан барих, аюулгүйн зон татах, анхааруулах тэмдэг плакат өлгөх, шаарлагатай гэж үзвэл доош юм унахаас сэргийлсэн тор татах хүртэл ажил зохион байгуулахыг гүйцэтгэгч байгууллагын удирдлага, ажил удирдагч, ажил гүйцэтгэгч нар шууд хариуцна.
6. Ажлын байранд галын хэсгийн зөвшөөрөлгүй, галын нарядгүйгээр гагнуурын болон галын аюултай ажил гүйцэтгэх, ил гал түлэх, тамхи татахыг хориглоно.

### Тав. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Механик цехийн Өргөх зөөх механизмын бригад  
Гүүрэн крануудын иж бүрэн оношлогоог хийх ажлын эзэлхүүн

№	Хийгдэх ажил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тайлбар
1	Гүүрэн кранд урьдчилсан үзлэг хийх	ш	8	
2	Гүүрэн краныг цэвэрлэх	ш	8	
3	Краны үндсэн дам нурууны металл хийцэд хэмжилт хийх	ш	8	
4	Краны хажуугийн дам нурууны металл хийцэд хэмжилт хийх	ш	16	
5	Краны гүүрийн механизмд хэмжилт хийх	ш	16	
6	Гүүрийн эргэх механизмын хамгаалалтуудыг шалгах	ш	32	
7	Гүүрийн механизмын тормозны механизмын шкив, накладын элэгдлийг хэмжих	ш	16	
8	Краны тэргэнцэрийн дам нурууны металл хийцэд хэмжилт хийх	ш	8	
9	Краны тэргэнцэрийн механизмд хэмжилт хийх	ш	8	
10	Тэргэнцэрийн эргэх механизмын хамгаалалтуудыг шалгах	ш	8	
11	Тэргэнцэрийн механизмын тормозны механизмын шкив, накладын элэгдлийг хэмжих	ш	8	
12	Краны тэргэнцэрийн дам нурууны металл хийцэд хэмжилт хийх	ш	48	
13	Үндсэн өргүүрийн механизмд хэмжилт хийх	ш	8	
14	Үндсэн өргүүрийн барабанд хэмжилт хийх	ш	8	

15	Үндсэн өргүүрийн дамжуулгын дамруудад хэмжилт хийх	ш	44	
16	Үндсэн өргүүрийн тэнцүүлэгч дамруудад хэмжилт хийх	ш	28	
17	Үндсэн өргүүрийн ган татлагыг хэмжих, норм шалгах	м	1412	
18	Үндсэн өргүүрийн эргэх механизмын хамгаалалтуудыг шалгах	ш	16	
19	Үндсэн өргүүрийн тормозны механизмын шкив, накладын элэгдлийг хэмжих	ш	8	
20	Туслах өргүүрийн механизмд хэмжилт хийх	ш	8	
21	Туслах өргүүрийн барабанд хэмжилт хийх	ш	8	
22	Туслах өргүүрийн дамжуулгын дамруудад хэмжилт хийх	ш	16	
23	Туслах өргүүрийн тэнцүүлэгч дамруудад хэмжилт хийх	ш	16	
24	Туслах өргүүрийн ган татлагыг хэмжих, норм шалгах	м	720	
25	Туслах өргүүрийн эргэх механизмын хамгаалалтуудыг шалгах	ш	8	
26	Туслах өргүүрийн тормозны механизмын шкив, накладын элэгдлийг хэмжих	ш	8	
27	Тэргэнцэрийн механизмын замын рельсэд хэмжилт хийх	м	161	
28	Тэргэнцэрийн механизмын замын рельсийн газардуулгыг шалгах, хэмжих	ш	16	
29	Краны замыг хэмжих	м	3072	
30	Краны замын рельсны суурийн балканы хоорондын холбоос шалгах, хэмжих	ш	288	
31	Кабелийн дүүжинт бэхэлгээний ган татлага, ролькуудын үзэх	ш	40	
32	Цахилгаан шитэнд үзлэг хийх, ажиллагааг шалгах	ш	8	
33	Механизмуудын төгсгөлийн салгууруудын ажиллагаа хэвийн эсэх, дүрмийн дагуу тогтоогдсон зайд тасарч байгааг шалгах	ш	64	
34	Механизмуудын төгсгөлийн тулгуур, бамбайнд үзлэг хийх ,шаардлага хангаж байгаа эсэх	ш	64	
35	Троллейны шугам, хөндийрүүлэгт үзлэг хийх	ш	624	
36	Троллейны шугмын анхааруулах гэрэлд үзлэг хийх	ш	48	
37	Краны кабины дуут дохиололд үзлэг шалгалт хийх	ш	8	
38	Краны даацын хэсгийн бэхлэгээнд нарийвчилсан үзлэг хийх, хэмжих	ш	8	
39	Краны металл хийцийн гагнуурын оёдолд ан цав үүссэн эсэхийг тодорхойлох			
40	Краны гүүрийн металл хийцэд мушгралт, гулзайлт, хонхойлт, муруйлт, гажилт, шахалт, суналт байгаа эсэхийг үзэх , хэмжих, тодорхойлох	ш	16	
41	Зэврэлт үүссэн бол металлын хэмжилт хийх	ш	8	
42	Краны дугуйны бэхэлгээний хэсэгт металлын хэв гажилт байгаа эсэхийг хэмжих, тодорхойлох	ш	64	

43	Краны тэргэнцэр, гүүрийн замын рельсын бэхэлгээнд металл хийцийн гажилтыг хэмжих	ш	8064	
44	Краны кабины бэхэлгээг үзэх, хэмжих	ш	8	
45	Краны бүслүүрт ташуу хийцүүдийг гагнасан хэсэгт хэмжилт хийх	ш	64	
46	Краны гол дам нурууны хөндлөн огтлол өөрчлөгдөх хэсэгт хэмжилт хийх	ш	32	
47	Статик, динамик туршилт хийх ачааг зөөж оруулж байрлуулах	ш	40	
48	Хэвийн ачаа өргөөгүй үеийн гол дам нуруунд хэмжих	ш	8	
49	Статик туршилтын ачааг өргөх, гол дам нуруунд хэмжилт хийх	ш	8	
50	Статик туршилтын ачааг буулгах, гол дам нуруунд хэмжилт хийх	ш	8	
51	Динамик туршилтыг механизмуудад хийх	ш	32	
52	Туршилтын ачааг гаргах, зөөвөрлөх	ш	40	
53	Даацын металл хийцэд хийсэн туршилтын акт бүрдүүлэх	ш	16	
54	Хэмжилт ба гадаад үзлэгээр металл болон гагнуурын холболтыг шалгасан тухай дүгнэлт гаргах	ш	16	
55	Өргөн тээвэрлэх байгууламжид хийсэн иж бүрэн шинжилгээ, оношлогооны техникийн тайлан гаргах	ш	16	



Зургаа. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

**“ДЦС-3” ТӨХК-ын дарга Ч.Чинбат танаа**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх** 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
  2. **Төслийн менежерийн шийдвэр** 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
  3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх** 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
  4. **Аюулгүй байдал** 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.  
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
  5. **Зааварчилгаа** 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
  6. **Маргааныг шийдвэрлэх** 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
- Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**
7. **Ажлын хөтөлбөр** 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.  
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
  8. **Зөрчил, гологдол илрүүлэх** 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт,

туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

- 9. Зөрчил, гологдол арилгах**
- 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.  
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.  
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.  
17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах** 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.  
18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:  
(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;  
(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;  
(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;  
(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг  
цуцалсан  
үед хийх  
төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээ  
с чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

**Найм. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>Гүүрэн крануудад иж бүрэн оношлогоо, техникийн иж бүрэн магадлал хийлгэх</i>
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь <i>Гүүрэн крануудад иж бүрэн оношлогоо, техникийн иж бүрэн магадлал хийлгэх ажлаас бүрдэнэ.</i>  Ажлын талбай нь Станцын хашаа ӨДЗуух, ДДЗуух, ӨДТурбин, ДДТурбин, ТДЦехүүдэд байршина.
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь: <i>Механик цехийн дарга Ц.Батмөнх</i>
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр <i>2020 оны 04-р сарын 01</i>  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>2020 оны 05-р сарын 10</i>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <i>90</i> хоног байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,3 хувь байна. <sup>3</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 30 хувь байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -иар тооцно.
<b>ГЕН 20.1</b>	Гэрээт ажлын хөлсний 90%-ийг гэрээт ажлыг хүлээн авч, гэрээ дүгнэсэн акт батлагдсанаас хойш хуанлийн 30 хоногт багтаан шилжүүлнэ. Засварын баталгаат хугацаанд гэрээт ажлын хөлсний 10%-ийг захиалагчийн дансанд байршуулна.

<sup>3</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>4</sup>

БАТЛАВ  
“ДЦС-3” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ

Ч.ЧИНБАТ

БАТЛАВ  
“.....” ХХК-ИЙН ЗАХИАРЛ

.....

### ..... ИХ ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2020 оны .... -р сарын . . .-ны өдөр

№.....

Улаанбаатар хот

### ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.

Нэг талаас “ДЦС-3” ТӨХК-г төлөөлж Тэргүүн дэд захирал, ерөнхий инженер ..... /цаашид “захиалагч” гэх/, нөгөө талаас “.....” ХХК-ийг төлөөлж инженер ..... /цаашид “гүйцэтгэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 343–358 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйл, “ДЦС–3” ТӨХК-ийн Харьцуулалтын ажлын хэсгийн 20.... оны .....-р сарын .....-ны өдрийн хурлын ..... тоот шийдвэр, Харьцуулалтын ажлын хэсгийн ЗХА-..... тоот зөвлөмж, 2020 оны Бизнес төлөвлөгөө, Удирдлагын шийдвэрийг үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

“.....”-ын ажлыг тендерийн баримт бичигт заасан шалгаруулалт, шаардлагад нийцүүлэн графикт хугацаанд чанартай, технологийн дагуу хийж гүйцэтгэн хүлээлгэж өгөх, захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтоох, төлбөр тооцоог гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэхэд гэрээний зорилго оршино.

### НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. “.....”-ын ажлыг 2020 оны .....-р сарын .....-ноос 2020 оны .... -р сарын ..... -ний хооронд багтаан хийж хүлээлгэн өгнө.

1.2. Гэрээт ажлын үнэ Харьцуулалтын ажлын хэсгийн ..... тоот зөвлөмжийн дагуу НӨАТ болон бусад бүх зардлыг тооцоод ..... /...../ төгрөг байна.

1.3. Гэрээт ажлын хөлсний 90%-ийг гэрээт ажлыг хүлээн авч, гэрээ дүгнэсэн акт батлагдсанаас хойш хуанлийн 30 хоногт багтаан шилжүүлнэ.

### ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

<sup>4</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

- 2.1. Засварын ажлыг гэрээнд заасан хугацаанд хүлээн авч санхүүжилтийг гэрээ дүгнэсэн акт болон нэхэмжлэлийг үндэслэн хийж гүйцэтгэнэ
- 2.2. Гүйцэтгэсэн ажлыг хугацаанд комисс гарган хүлээн авна.
- 2.3. Баталгаат хугацаа хүлээлгэн өгснөөс хойш 3 сар буюу 2200 цаг ажилласан байна. Гэрээт ажлын баталгаат хугацаа дууссаны дараа баталгаат хугацааны 10%-г олгох хурлын тэмдэглэлийг үндэслэн гүйцэтгэгч талд шилжүүлнэ.
- 2.4. Баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой гэмтэл доголдол гарвал дахин үнэ төлбөргүй хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 2.5. Захиалагч нь их засварын ажилд шаардагдах сэлбэг материалыг цаг хугацаанд нь олж нийлүүлэх үүрэгтэй.

### **ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1. Засварыг гэрээнд заасан хугацаанд технологийн дагуу чанартай хийж хүлээлгэн өгнө.
- 3.2. “.....”-ын ажилтай холбогдолтой техникийн бичиг баримтыг бүрдүүлэх.
- 3.3. Засварын ажил нь чанарын шаардлага хангахгүй тохиолдолд гүйцэтгэгч хугацаа алдалгүй өөрийн хүчээр хийж өгөх ба гарсан бүх зардлыг хариуцна.
- 3.4. Засварын хугацаанд ХАБЭА-н болон бусад аюулгүй ажиллагааны бүх арга хэмжээг бүрэн хариуцаж ажиллана.
- 3.5. Засварын баталгаат хугацаанд гэрээт ажлын хөлсний 10%-ийг захиалагчийн дансанд байршуулна.

### **ДӨРӨВ. ГЭРЭЭ ДҮГНЭЖ ХАРИУЦЛАГА ТООЦОХ**

- 4.1 “.....”-ын ажлыг бүрэн дуусгаж техникийн бичиг баримт бүрдэлтийг хийж захиалагч талд хүлээлгэн өгч гэрээг дүгнэнэ.
- 4.2. Гүйцэтгэгчийн буруугаас засварын ажлын хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.3 хувиар хоног тутам гүйцэтгэгч алданги хүлээх ба уг алданги нийт гэрээний үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.
- 4.3. Захиалагчийн буруугаас төлбөр төлөх хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувиар хоног тутам алданги хүлээх ба нийт үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.

### **ТАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

- 5.1. Давагдашгүй хүчин зүйлд байгалийн гамшиг, гал түймэр, үер, шуурга, газар хөдлөлт, дайн, эдийн засгийн болон импортын шууд хориг, энэ гэрээг баталсны дараа үүсч болзошгүй онцгой байдалд хүргэсэн бусад нөхцлүүд гэрээг биелүүлэхэд саад учруулсан зүйлүүд орно.
- 5.2. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас шууд шалтгаалан энэ гэрээгээр хүлээсэн үүргээ хэсэгчлэн буюу бүхлээр нь биелүүлэхгүйд хүрсэн бол талууд хариуцлагыг хүлээхгүй.
- 5.3. Давагдашгүй хүчин зүйл үүссэнээс хойш 7 хоногийн дотор гэрээний үүргээ биелүүлэх бололцоогүй болсон тал нь нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.
- 5.4. Хэрэв давагдашгүй хүчин зүйлс гэрээний биелэлтэнд 1 сарын турш үйлчлэх тохиолдолд үүргээ биелүүлж чадахгүй болсон тал цаашид энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй татгалзах эрхтэй. Энэ тохиолдолд талууд гэрээг хүчингүй болсон хугацаагаар ажлын гүйцэтгэлийн тооцоог дуусгана.

### **ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**



6.1. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

6.2. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж гүйцэтгэгч нэг хувь, захиалагч гурван хувийг авах бөгөөд хувиуд нь ижил тэгш хүчинтэй.

6.3. Талууд аль нэг нь гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.

6.4. Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

6.5. Талуудын санал зөрөөтэй асуудлаар зөвшилцөлд хүрч чадахгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.6. Шүүхийн шийдвэр нь эцсийн бөгөөд талууд түүнийг заавал биелүүлнэ.

6.7. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд үндсэн гэрээний салшгүй хэсэг байна.

6.8. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болно.

#### **ДОЛОО. ТАЛУУДЫН ХАЯГ:**

##### **ЗАХИАЛАГЧИЙН ХАЯГ:**

Хаяг: Хан–Уул дүүрэг. 3-р хороо

“ДЦС–3” ТӨХК-ийн байр

Утас: 11–343024

##### **ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХАЯГ:**

..... дүүрэг , .....-р хороо

.....

РД: .....

Утас: .....

Банк:

Данс:

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

##### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“ДЦС-3” ТӨХК-ийн Тэргүүн дэд

захирал, ерөнхий инженер

##### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“.....” ХХК-ийн

инженер

.....

ЗХА –ны дарга

СБХ –ийн дарга

Ерөнхий нягтлан бодогч

Механик цехийн дарга

Гэрээний мэргэжилтэн

Хянасан: Хуулийн мэргэжилтэн